



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ **2020**
ТАЙЛАН

АГУУЛГА

Агуулга, бүлгийн нэр	Хуудасны дугаар
1. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	3
2. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ	4
2.1 Төсвийн шууд захирагчийн тайлан	5
2.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлан	7
2.3 Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.4 Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан	7
2.5 Засгийн газрын тусгай сан болон бусад сангийн санхүүгийн тайлан	8
2.6 Төсөв захирагчдын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитын төлөвлөлтийн үе шат болон завсрын аудит	9
3. ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ	9
3.1 Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг	9
3.2 УИХ-ын ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гаргах	10
3.3 Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүн	10
4. НИЙЦЛИЙН АУДИТ	11
4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	11
4.2 Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны хөрөнгийн зарцуулалт	11
5. ИТХ-ЫН ЗАХИАЛГА, ӨӨРИЙН САНААЧИЛГААР ГҮЙЦЭТГЭСЭН АУДИТ	12
5.1 Орон нутгийн төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн	13
5.2 Мэргэжлийн боловсрол олгох үйл ажиллагааны үр дүн	13
5.3 Орон нутагт тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа дүрэм, журмын хэрэгжилт, үр дүн	13
5.4 МСҮТ болон ерөнхий боловсролын сургуулийн дотуур байр болон цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын зарцуулалт, үр дүн	14
5.5 Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилт	14
5.6 Аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх орон нутгийн сонгуулийн тойрогт нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох	15
5.7 Аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх орон нутгийн сонгуулийн тойрогт нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох	15
5.8 Орон нутгийн ИТХ-ын ээлжит сонгуулийн жилийн 06 дугаар сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд тухайн нам, иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивыг хянаж, баталгаажуулах	15
5.9 Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргах	16
6. ДОТООД АЖИЛ	16
6.1 Дотоод сургалт	16
6.2 Архив, бичиг хэрэг	17
6.3 Ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа	18
6.4 Дотоод зохион байгуулалтын бусад асуудал	18
6.5 Хүний нөөц, шагнал урамшуулал	18
6.6 Шинэ санал, санаачилга	19
7. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	19
8. ТӨЛБӨРИЙН АКТ, АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛАХ АЖИЛ	20
9. ДҮГНЭЛТ, САНАЛ	21
9.1 Дүгнэлт	20
9.2 Санал	20

Товчилсон үгийн жагсаалт

ҮАГ	Үндэсний аудитын газар
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны татвар
АНСДИТХСТХ	Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль
БОНБУ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ
БОМТ	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
БСУГ	Боловсрол, соёл урлагийн газар
ГА	Гүйцэтгэлийн аудит
ДГА	Дорноговь аймаг
ЗГТС	Засгийн газрын тусгай сан
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ММНБИ	Монголын Мэргэшсэн нягтлан бодогчдын институт
МУ	Монгол Улс
МУЕА	Монгол улсын Ерөнхий аудитор
МСҮТ	Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
НА	Нийцлийн аудит
НББ	Нягтлан бодох бүртгэл
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОБГ	Онцгой байдлын газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨХХК	Орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
СХ	Сонгуулийн хороо
СХАА	Санхүүгийн хяналт, аудитын алба
СХС	Сум хөгжүүлэх сан
ТАГ	Төрийн аудитын газар
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТББ	Төрийн бус байгууллага
ТБОНӨААН	Төрийн болон орон нутгийн өмчийн аж ахуйн нэгж
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТӨААН	Төрийн өмчийн аж ахуйн нэгж
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үзүүлэлт
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
УБХ	Улсын бүртгэлийн хэлтэс
УИХ	Улсын Их Хурал
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХАК	Хувийн аудитын компани
ХБАК	Хараат бус аудитын компани
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

1 УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар нь Монгол Улсын Ерөнхий аудиторовын дэвшүүлсэн “Төрийн аудитын байгууллагын стандарт, эрх зүйн орчны шинэтгэлийг хэрэгжүүлэх” зорилт, Төрийн аудитын байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хүрээнд 2020 онд нийт 64 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үүнээс бүрэн хийж гүйцэтгэсэн 48 ажил, дутуу хийгдсэн 7 ажил, тодорхой шалтгааны улмаас хийгдээгүй 9 арга хэмжээ байна.



Монгол Улсын Ерөнхий аудиторовын тушаалаар батлагдсан орон тоогоор 11 үндсэн ажилтан, 2 гэрээт ажилтан нийт 1350 хүн-өдөр, 3792 илүү цаг ажиллалаа.

Тус байгууллага нь санхүүгийн тайлангийн, гүйцэтгэлийн, нийцлийн аудитын алба болон дэмжих баг гэсэн бүтэцтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Санхүүгийн тайлангийн аудитын албанд 4, гүйцэтгэлийн болон нийцлийн аудитын албанд тус бүр 2 аудитор ажиллаж байна.

Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу 6 гүйцэтгэлийн аудит, 8 нийцлийн аудит, улс, орон нутгийн төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, Засгийн газрын тусгай сангийн нийт 222 байгууллагын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн аудитыг хийж гүйцэтгэлээ. Төлөвлөгөөний дагуу тайлант онд дуусах 2 нийцлийн аудитыг хийгдэж байна.

2020 онд гүйцэтгэсэн аудитаар нийт 236,565.4 сая төгрөгийн 1128 алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 202,539.5 сая төгрөгийн 528 алдааг залруулж, 74.2 сая төгрөгийн зөрчилд 60 төлбөрийн акт, 2,861.8 сая төгрөгийн зөрчилд 112 албан шаардлага тогтоож, 31,089.9 сая төгрөгийн зөрчилд 410 зөвлөмж, 18 албан тушаалтанд хариуцлага тооцох 11 албан шаардлага хүргүүлээ.

Тайлант онд тогтоосон акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг доорх графикт харуулав.




График №1. Алдаа, зөрчлийн шийдвэрлэлтийн хэрэгжилт

Тайлант онд хэрэгжвэл зохих төлбөрийн актын биелэлт 95.2 хувь, албан шаардлагын биелэлт 74.3 хувь, зөвлөмжийн хэрэгжилт 76.3 хувьтай байна.

Өмнөх онд тогтоосон төлбөрийн актын үлдэгдэл 53.7 сая төгрөгийн 35 актаас 22.3 сая төгрөгийн 5 төлбөрийн акт, оны эхний үлдэгдэл болох 7,383.9 сая төгрөгийн 26 албан шаардлагаас 320.6 сая төгрөгийн 19 албан шаардлага, 7,429.8 сая төгрөгийн 58 зөвлөмжөөс 3,841.2 сая төгрөгийн 33 зөвлөмж тайлант онд хэрэгжсэн ба өмнөх оноос шилжин ирсэн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлт дунджаар 56.3 хувьтай байна.

Тайлант хугацаанд төлбөрийн акт, албан шаардлагын биелэлтийг хангуулж, орон нутгийн төсөвт нийт 45.5 сая төгрөгийг төвлөрүүлж, 2,091.9 сая төгрөгийн 53 санхүүгийн үр өгөөж, 6 санхүүгийн бус үр өгөөжийг хүлээн зөвшөөрүүлж ажилласан.

2 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 220 байгууллага, тусгай сангуудыг хамруулахаас 10 байгууллагад итгэл үзүүлж, төлөвлөгөөнд тусгагдаагүй 2 байгууллагыг ҮАГ-аас өгсөн чиглэлийн дагуу түүвэрт хамруулан, нийт 212 төсөв захирагч, сан, ТБОНӨААН-ийн 2019 оны санхүүгийн тайланд аудит хийлээ. Үүнээс 49 хувь буюу 104 тайланг Төрийн аудитын газар, 51 хувь буюу 108 тайланг ХБАК-аар гүйцэтгүүллээ. График №2.




График №2. Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан байгууллагын үзүүлэлт

Санхүүгийн тайлангийн аудитыг ТАГ-ын нийт 6 аудитор гүйцэтгэж, 393 хүн-өдөр, 563 илүү цаг ажилласан байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны А/191 тоот тушаалаар батлагдсан “Санхүүгийн тайланд аудит хийх хараат бус аудитын этгээдийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журам”-ыг үндэслэн хараат бус аудитын компанийг сонгон шалгаруулж “Шилэн баланс аудит” ХХК, “Уваа-Уул аудит” ХХК, “Ингүүмэл жаргалант аудит” ХХК-уудтай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ажиллалаа.

Санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагчийн 118, төсвийн төвлөрүүлэн захирагчийн 14, төсвийн ерөнхийлөн захирагчийн 1, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн 7, засгийн газрын тусгай сангийн 4, нийт 144 санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, төсвийн шууд захирагчийн 37, сангийн 29, ТӨААН-ын 2 тайланд үе шатны ажлыг хэсэгчлэн хийлээ. Аудитаар нийт 122 байгууллагад “Зөрчилгүй”, 21 байгууллагад “Хязгаарлалттай”, 1 байгууллагын

санхүүгийн тайланд “Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан” дүгнэлт өгсөн. Доорх графикт санхүүгийн тайлангийн аудитын хэлбэрийг сүүлийн 3 жилээр харуулав.



Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 210,744.4 сая төгрөгийн 998 алдаа, зөрчил илрүүлснээс аудитын явцад 202,539.5 сая төгрөгийн 528 алдааг залруулж, 74.2 сая төгрөгийн зөрчилд 60 төлбөрийн акт тогтоон, 1,119.3 сая төгрөгийн зөрчилд 78 албан шаардлага, 7,011.3 сая төгрөгийн зөрчилд 314 зөвлөмж хүргүүллээ. Мөн хязгаарлалттай, санал дүгнэлт өгөхөөс татгалзсан дүгнэлт авсан байгууллагуудын холбогдох 18 албан тушаалтанд хариуцлага тооцуулах 11 албан шаардлага хүргүүллээ.

Тайлант хугацаанд 70.7 сая төгрөгийн 50 төлбөрийн акт хэрэгжиж, биелэлт 95.2 хувь, 861.9 сая төгрөгийн 66 албан шаардлага хэрэгжиж, албан шаардлагын хэрэгжилт 84.6 хувьтай, 5,980.8 сая төгрөгийн 244 зөвлөмж хэрэгжиж, зөвлөмжийн биелэлт 77.7 хувьтай байна.

Тайлант онд тогтоосон төлбөрийн актаас 30.6 сая төгрөгийн 50 санхүүгийн үр өгөөжийг хүлээн зөвшөөрүүлээд байна.

2.1. Төсвийн шууд захирагчийн тайлан

Аудитад 165 төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланг хамруулахаас 10 санхүүгийн тайланд итгэл үзүүлж, 155 төсвийн шууд захирагчийн 2019 оны санхүүгийн тайланг аудит хамрууллаа. Үүнээс 118 санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, 37 санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэлээ. Тус аудитаар 103 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, 15 байгууллагын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн. Санхүүгийн аудитад хамрагдсан байгууллага, аудитаар өгсөн санал дүгнэлтийг өмнөх онуудын мэдээтэй харьцуулан доорх графикт харуулав.




График №3. ТШЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн дүгнэлтийн төрөл

Тайлант онд Сайншанд сумын 1, 4 дүгээр сургууль, Айраг, Алтанширээ, Улаанбадрах сумын сургууль, Замын-Үүд сумын 1, 4 дүгээр цэцэрлэг, Сайншанд сумын 7 дугаар цэцэрлэг, Даланжаргалан сумын цэцэрлэг, Дэлгэрэх, Хатанбулаг, Хөвсгөл сумын ЗДТГ, Хилийн 0108 дугаар анги, аймгийн Нэгдсэн эмнэлэг, аймгийн Цагдаагийн газарт тус тус “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн.

Төсвийн шууд захирагчдын 2019 санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг ангилан харуулбал:

Алдаа, зөрчлийн ангилал	Дүн, сая төгрөг	Хувиар
Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой	3,491.0	47.2%
Хууль тогтоомжийн хэрэгжилт, зориулалт бус зарцуулалт бус зарцуулалт, худалдан авах ажиллагаатай холбоотой	3,001.3	40.6%
Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, орлого бүрдүүлэлттэй	622.5	8.4%
Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой	250.4	3.4%
Арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй холбоотой	29.4	0.4%
Нийт	7,394.6	100.0%

Төсвийн шууд захирагчийн тайланд нийт 7,394.6 сая төгрөгийн 839 алдаа, зөрчил илрүүлж, 3,044.9 сая төгрөгийн 473 алдааг аудитын явцад залруулж, 73.5 сая төгрөгийн зөрчилд 58 төлбөрийн акт, 824.5 сая төгрөгийн зөрчилд 49 албан шаардлага тогтоон, 3,451.8 сая төгрөгийн зөрчилд 258 зөвлөмж өгч, хязгаарлалттай санал дүгнэлт авсан 8 холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлагыг хүргүүлээ.

2.2. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлан

Аудитад 14 сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланг бүрэн хамрууллаа. Тус аудитаар 9 санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, Хатанбулаг, Алтанширээ, Дэлгэрэх, Сайхандулаан, Хөвсгөл сумын ТТЗ-ийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлтийг өгөв. Аудитаар илэрсэн зөрчлийг ангилан харуулбал:

- Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 10,308.5 сая төгрөгийн 11 алдаа
- Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 53.1 сая төгрөгийн 7 зөрчил,
- Дотоод хяналт болон орон нутгийн орлого бүрдүүлэлттэй холбоотой 3 зөрчил.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 10,361.6 сая төгрөгийн 21 алдаа зөрчил илрүүлж, 10,308.5 сая төгрөгийн 11 алдааг залруулж, 53.1 сая төгрөгийн 3 зөвлөмжийг хүргүүлэн, “Хязгаарлалттай” санал дүгнэлт авсан байгууллагын 8 холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүллээ.

2.3. Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайланд ТТЗ-ийн 14, орон нутгийн төсөвт болон тусгай шилжүүлгийн 125, ОНӨХХК 6, тусгай сан 29, нийт 175 санхүүгийн тайлан нэгтгэсэн байна. Аймгийн ТЕЗ-ийн 2019 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 186,612.1 сая төгрөгийн 18 алдаа зөрчил, төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланд 352.0 сая төгрөгийн 2 зөрчил илрүүлсэн. Үүнд:

- Санхүүгийн тайланд устгах бичилтийг хийгээгүй,
- Соёлын болон тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын байр ашиглалтын зардлын төсвийг бодитой төлөвлөөгүй,
- Харьяа байгууллагуудын алдаа, зөрчлийн дүн буураагүй,
- Аймгийн төсвийг алдагдалтай баталсан,
- Аймгийн төрийн сан, ОНХС, СХС, хөрөнгө оруулалтын санхүүгийн үйл ажиллагаанд нягтлан бодох бүртгэлийг хөтлөөгүй зэрэг байна.

Аудитаар аймгийн ТЕЗ-ийн 2019 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгагдсан 67,881.4 сая төгрөгийн орлого, 68,042.7 сая төгрөгийн зарлагыг баталгаажуулав.

2.4. Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан

Аудитад 7 аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланг гүйцэтгэхээр төлөвлөж, 9 санхүүгийн тайланд аудит хийсэн. Үүнээс 7 байгууллагад дүгнэлт гаргаж, 2 байгууллагыг түүвэрт хамрууллаа. Тус аудитаар 5 санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, Дагшин-Эрдэнэ ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай”, Нийтлэг үйлчилгээний газрын санхүүгийн тайланд “Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан” дүгнэлтийг өгсөн.

Сүүлийн 3 жилд ТБОНӨААН-ийн санхүүгийн тайланд хийсэн аудитын хэлбэр, дүгнэлтийн төрлийг дараах графикт харуулав.




График №4. ТБОНӨААН-ийн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн дүгнэлтийн төрөл

Тайлант оны аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг ангилан харуулбал:

- Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 695.5 сая төгрөгийн 12 зөрчил,
- Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 144.7 сая төгрөгийн 27 алдаа,
- Дотоод хяналт, худалдан авалттай холбоотой 6 зөрчил байна.

Аудитаар нийт 840.2 сая төгрөгийн 45 алдаа зөрчил илрүүлэн, үүнээс 47.9 сая төгрөгийн 2 алдааг залруулж, 0.7 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, журам болон гэрээний заалтыг өөрчлөх, өмнөх онд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх 2 албан шаардлага хүргүүлж, нийт 791.6 сая төгрөгийн 32 зөвлөмж хүргүүллээ.

2.5. Засгийн газрын тусгай сан болон бусад сангийн санхүүгийн тайлан

Тайлант хугацаанд Засгийн газрын 4 тусгай сан, орон нутгийн хөгжлийн 15 сан, сум хөгжүүлэх 14 сангийн 2019 оны санхүүгийн тайланд аудит хийхээр төлөвлөн, бүрэн хэрэгжүүлсэн. Үүнээс ЗГТС-ийн тайланд дүгнэлт гаргаж, “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн бол бусад 29 сангийн тайланд үе шатны ажлыг хэсэгчлэн хийж аудитыг гүйцэтгэлээ.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг ангилан харуулбал:

- Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 2,718.7 сая төгрөгийн,
- Хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 2,357.3 сая төгрөгийн,
- Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой 107.8 сая төгрөгийн алдаа, зөрчлийг илрүүлсэн.

Засгийн газрын тусгай сан болон бусад сангийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 5,183.8 сая төгрөгийн 76 алдаа, зөрчлийг илрүүлж, 2,526.2 сая төгрөгийн 30 алдааг аудитын явцад залруулж, 294.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч, 2,362.8 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүллээ.

2.6. Төсөв захирагчдын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитын төлөвлөлтийн үе шат болон завсрын аудит

Төсөв захирагчдын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитад нийт 221 байгууллагыг хамруулахаар төлөвлөж, баталсан. Үүнээс ТАГ 98 төсөв захирагчийн тайланд аудит хийхээр төлөвлөж, тайлант онд нийт 97 санхүүгийн тайлангийн аудитын төлөвлөлтийн үе шатны ажлыг, 30 байгууллагын завсрын аудитыг гүйцэтгэхээр төлөвлөсөн.

Төлөвлөгөөний дагуу 12 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар нийт 70 байгууллагын төлөвлөлт, 28 байгууллагын завсрын аудитыг хийхээр батлагдсанаас 73 байгууллагын аудитын төлөвлөлтийн үе шатны ажил, 21 байгууллагын санхүүгийн тайланд завсрын аудитыг гүйцэтгээд байна. Тушаалаар батлагдсан төлөвлөлтийн үе шатны болон завсрын аудитыг тайлант онд хуваарийн дагуу бүрэн гүйцэтгэнэ.

3 ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

Төрийн аудитын газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр 6 гүйцэтгэлийн аудит хийхээр батлагдсанаас ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар 3 аудит, өөрийн санаачилгаар 3 аудитыг хийж гүйцэтгэлээ. Аудитыг 7 аудитор нийт 250 өдөрт гүйцэтгэж, 447 илүү цаг ажилласан байна.

Гүйцэтгэлийн аудитаар нийт 20,046.2 сая төгрөгийн 62 зөрчил илрүүлж, 1,229.3 сая төгрөгийн зөрчилд 13 албан шаардлага тогтоож, 18,816.9 сая төгрөгийн зөрчилд 49 зөвлөмж хүргүүллээ.

Тайлант хугацаанд хэрэгжвэл зохих 13 албан шаардлагын 38.5 хувь буюу 1,224.5 сая төгрөгийн 5 албан шаардлага, 16,098.0 сая төгрөгийн 41 зөвлөмжийн 68.3 хувь буюу 12,946.3 сая төгрөгийн 28 зөвлөмж хэрэгжсэн байна. Хугацаа болоогүй 8 зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Мөн тайлант хугацаанд 2 санхүүгийн бус үр өгөөж хүлээн зөвшөөрүүлсэн байна.

3.1. Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг /код: ДГА-2020/02-ГА, ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар/.

Аудитад тус аймагт 2019 онд улсын төсвөөр хэрэгжсэн ТАХ-г хамруулан, 2020.03.13-ны өдрөөс 2020.05.07-ны өдрийг хүртэлх хугацаанд гүйцэтгэлээ. Тус аймагт 83.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 52 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн, 35.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тайлант онд олгохоор шийдвэрлэсэн байна.

Аудитын дүнд үндэслэн **“Хөрөнгө оруулалтыг төлөвлөх үйл явц хангалтгүй байгаагаас үр нөлөө, үр ашгийн тооцоо судалгаа хийгдээгүй ТАХ-ыг төлөвлөж, хэрэгжүүлсэн байна”** гэсэн нэгдсэн дүгнэлтийг өгсөн.

Хөрөнгө оруулалтыг салбарын болон орон нутгийн хөгжлийн хэрэгцээнд тулгуурлан шат шатанд төлөвлөж байгаа ч үр ашгийг тооцож судлаагүй, хөрөнгө оруулалтаас бий болох үр ашиг, нийгмийн болон эдийн засгийн тооцоо судалгаагүй,

ТЭЗҮ, зураг, төсөв боловсруулагдаагүй ажлыг төлөвлөснөөс ТАХ нь гэрээний хугацаанд хийгдээгүй, чанаргүй хийгдсэн зэрэг зөрчил нийтлэг илэрч байна.

Аудитаар нийт 5,943.1 сая төгрөгийн зөрчил илрүүлж, илүү олгосон магадлалгүй ажлын зардал төлүүлэх, гэрээний алданги тооцох, ажил дуусгуулах, гэрээ дүгнэж алданги тооцуулах, хөрөнгө данс бүртгэлд бүртгэх, гэрээний тусгай нөхцөлд тусгасан заалтын хэрэгжилтийг хангуулах тухай 1,062.4 сая төгрөгийн 6 албан шаардлага тогтоож, 4,880.7 сая төгрөгийн зөрчилд 13 зөвлөмж өгөв.

3.2. УИХ-ын ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гаргах /код: ДГА-2020/04-ГА, УАГ-ын нэгдсэн удирдамжаар/.

Аудитад Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд аймаг, сумдын сонгуулийн хороо, Улсын бүртгэлийн хэлтэс, Онцгой байдлын газрыг хамруулан 2020.07.03-ны өдрөөс 2020.08.17-ны хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэлээ.

СЕХ-оос аймгийн сонгуулийн хороонд 328.6 сая төгрөгийн, УБЕГ-аас аймгийн УБХ-т 64.6 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Аймгийн СХ-оос сумдын СХ-д олгох санхүүжилтийг СЕХ-оос ирүүлсэн зөвлөмж, аргачлалын дагуу тооцож, олгоогүй, батлагдсан төсвийг зориулалт бусаар, арвилан хэмнэлтгүй зарцуулсан, аймгийн СХ-оос сумдын СХ-д тавих хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй зэрэг зөрчил илэрсэн.

Аудитаар нийт 67.1 сая төгрөгийн зөрчил илрүүлж аймгийн Сонгуулийн хорооны холбогдох албан тушаалтнуудад 3 зөвлөмж хүргүүлээ.

3.3. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүн /код: ДГА-2020/05-ГА, УАГ-ын нэгдсэн удирдамжаар/.

Аудитад тус аймгийн БСУГ, ЗДТГ, МХГ, төрийн өмчийн 12, хувийн хэвшлийн 1 ЕБС-ийг хамруулан, 2020.08.20-ны өдрөөс 2020.10.30-ны өдрийг хүртэлх хугацаанд гүйцэтгэлээ.

Аудитын дүнд үндэслэн **“Үйл ажиллагааны үр дүн, төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх шаардлагатай байна”** гэсэн нэгдсэн дүгнэлтийг өгсөн.

Сургалтын материаллаг орчин хүртээмжтэй бус, сургалтын хэрэглэгдэхүүн дутагдалтай, мэргэжлийн боловсон хүчний хүрэлцээ дутагдалтайгаас суралцагч эзэмшвэл зохих мэдлэг, ур чадварыг бүрэн эзэмших боломжгүй, төсөв батлах, хуваарилах, зарцуулах, хяналт тавих үйл явц хуулийн хүрээнд хангалттай хэрэгжээгүй, санхүүжилтийг зориулалт бусаар зарцуулсан зэрэг зөрчил нийтлэг илэрсэн. Мөн ЕБС-ийн хичээл сургуулийн хэвийн үйл ажиллагаа алдагдаж, багш ажилчид, сурагчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлсөн зөрчил гарсан.

Аудитаар нийт 2,718.9 сая төгрөгийн зөрчил илрүүлж, ЕБС-ийн барилга, сурагчдын дотуур байрны эрүүл ахуй, аюулгүй байдал алдагдсан, сургалтад ашиглах боломжгүй болсон химийн урвалж бодисыг холбогдох журмын дагуу шийдвэрлэх тухай 4 албан шаардлага тогтоож, 2,718.9 сая төгрөгийн зөрчилд 8 зөвлөмж өгсөн.

4 НИЙЦЛИЙН АУДИТ

Төрийн аудитын газрын 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу нийт 9 нийцлийн аудит хийхээс ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар 2 аудит, аймгийн ИТХ-ын захиалгаар 1 аудит, хуулийн дагуу 3 аудит, өөрийн санаачилгаар 1 аудитыг хийж гүйцэтгэсэн. Мөн тайлант оны төлөвлөгөөнд тусгагдаагүй боловч, өмнөх онд гүйцэтгэлийн үе шатны ажлыг дуусгасан, тайлагналын үе шатны ажил хийгдээгүй байсан 1 аудитыг тайлант онд хийж гүйцэтгэсэн. Аудитыг 5 аудитор, 2 гэрээт аудитор нийт 333 өдөрт гүйцэтгэж, 583 илүү цаг ажилласан байна.

Нийцлийн аудитаар нийт 5,744.9 сая төгрөгийн 68 зөрчил илрүүлж, 513.2 сая төгрөгийн зөрчилд 21 албан шаардлага тогтоож, 5,261.7 сая төгрөгийн зөрчилд 47 зөвлөмж хүргүүлсэн.

4.1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт /Код:ДГА-2020/01-НА, нэгдсэн удирдамжаар/

Аудитад тус аймагт үйл ажиллагаа явуулдаг төрийн болон орон нутгийн өмчит 201 байгууллага, улс болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр ТАХ-г хэрэгжүүлсэн 159 ААНБ-ийг хамруулан 2020.02.13-ны өдрөөс 2020.05.15-ны өдрийг хүртэлх хугацаанд гүйцэтгэлээ.

Аудитын дүнд үндэслэн **“Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна”** гэсэн нэгдсэн дүгнэлтийг өгсөн.

Шилэн дансны нэгдсэн системд тогтмол мэдээлэх нийт мэдээллийг хугацаа хоцроох, огт мэдээлэхгүй байх, шилэн дансны мэдээллийг санхүүгийн мэдээллийн самбарт бүрэн мэдээлээгүй, зарим байгууллага мэдээллийн самбарыг олон нийт чөлөөтэй танилцах боломжтой газар байрлуулаагүй зэрэг зөрчил илэрсэн.

Мөн СХАА-ны хяналт хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг нарийвчлан зохицуулаагүй, хуулийн 3.1.3-т хамаарах 1 байгууллага шилэн дансны цахим системд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тушаал шийдвэрийг бүрэн мэдээлээгүй, улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ, бараа, ажил үйлчилгээ гүйцэтгэгч ААНБ-ууд хууль, журамд заасан мэдээлэх үүргээ хэрэгжүүлээгүй, аймаг, сумдын ИТХ-аас хяналт тавихдаа хуульд заасан байгууллагыг бүрэн хамруулаагүй, хяналтыг чанаргүй хэрэгжүүлсэн зэрэг зөрчил илэрсэн.

Аудитаар байршуулбал зохих 608 мэдээллийг хугацаа хоцроож, 3809 мэдээллийг мэдээлээгүй зөрчил илэрч, мэдээллийг нөхөн байршуулах 1 албан шаардлага, холбогдох албан тушаалтанд 5 зөвлөмж өгсөн.

4.2. Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны хөрөнгийн зарцуулалт /Код:ДГА-2020/07-НА, нэгдсэн удирдамжаар/

Аудитад аймаг, болон сумдын ОНХС-ийн 2019 оны үйл ажиллагааг хамруулан, 2020.08.18-ны өдрөөс 2020.11.13-ны өдрийг хүртэлх хугацаанд гүйцэтгэлээ. ОНХС-аас 2019 онд Дорноговь аймгийн ОНХС-д 5,544.1 сая төгрөгийн санхүүжилт олгож, аймгийн хэмжээнд 5,175.2 сая төгрөгийн, 128 шинэ төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Аудитын дүнд үндэслэн **“ОНХС-ийн үйл ажиллагааг төлөвлөх, эрэмбэлэх, батлах үе шатны ажлуудыг үр дүнтэй хэрэгжүүлээгүйгээс орон нутгийн хөгжлийг дэмжих зорилго хангагдаагүй байна”** гэсэн нэгдсэн дүгнэлтийг өгсөн.

ОНХС-ийн эх үүсвэрийг гадаад, дотоодын хандив, тусламжийн орлогыг боломжит хэмжээгээр төлөвлөөгүй, зарим сумд хандив тусламжийн орлогыг ОНХС-д төвлөрүүлэхгүй зарцуулсан, АМНАТ, ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн орлогын төлөвлөгөө биелээгүйгээс ОНХС-аас аймгийн ОНХС-д 1,251.8 сая төгрөгийн орлогын шилжүүлэг дутуу олгосон зэрэг зөрчил илэрсэн.

Мөн сумдад ТББ-ийг хангалтгүй боловсруулсан, тендерт оролцогчдын өрсөлдөх боломжийг хязгаарласан, ТЭЗҮ, зураг, төсөвгүй ТАХ-нд ХАА-г зохион байгуулсан, ТАХ-ний бодит гүйцэтгэлийг хянахгүйгээр санхүүжүүлсэн, ОНХС-ийн хөрөнгөөр 2019 онд МУ-ын Төсвийн тухай хуулиар зарцуулахыг хориглосон чиг үүргийн буюу иргэдийн саналд тусгаагүй, нийтийн эрх ашигт нийцээгүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлуулаагүй 68 ТАХ-г санхүүжүүлсэн, сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн 508.2 сая төгрөгийн хөрөнгийг ашиглагч байгууллагын бүртгэлд тусгаагүй, аймгийн ИТХ хяналтын хороог байгуулаагүй, сумдын ИТХ хяналт тавьж ажиллаагүй зэрэг нийтлэг зөрчил гарсан байна.

Аудитаар нийт 3,439.9 сая төгрөгийн зөрчил илрүүлж, чанаргүй хийгдсэн ажлыг дахин гүйцэтгүүлэх, зөрчил давтан гаргахгүй байх, хөрөнгө данс бүртгэлд бүртгэх тухай 508.2 сая төгрөгийн 14 албан шаардлага тогтоож, холбогдох албан тушаалтнуудад 12 зөвлөмжийг хүргүүлээ.

5

ИТХ-ЫН ЗАХИАЛГА, ӨӨРИЙН САНААЧИЛГААР ГҮЙЦЭТГЭСЭН АУДИТ

5.1. Орон нутгийн төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн /Код: ДГА-2020/01-ГА, өөрийн санаачилгаар/

Тус аймагт орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжсэн ТАХ-г хамруулан 2020.01.02-ны өдрөөс 2020.05.06-ны өдөр хүртэлх хугацаанд гүйцэтгэлээ. Тус аймагт 14.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 102 ТАХ-г хэрэгжүүлэхээс 10.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 2019 онд олгохоор төлөвлөсөн байна.

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн **“Хөрөнгө оруулалтын төлөвлөлт, худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг дээшлүүлэх шаардлагатай байна”** гэсэн нэгдсэн дүгнэлтийг өгсөн.

Аудитаар хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлага, урсгал зардал, санхүүжүүлэх эх үүсвэрийг тооцоогүй, нэр байршил тодорхойгүй, зураг төсөвгүй, газрын зөвшөөрөлгүй, хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй хөрөнгө оруулалтад ТАХ

төлөвлөж, ИТХ-аар батлуулсан, 2019 онд хэрэгжүүлэх ТАХ-ний тоо олон, барилгын компаниудын гэрээт ажлын хугацаа давхцах, тендерт оролцогч ирэхгүй байх, тендер дахин зарлах зэргээс ХАА төлөвлөсөн хугацаандаа хэрэгжээгүй, захиалагч гүйцэтгэлийн баталгаа шаардаагүйгээс гүйцэтгэлийн баталгаа байршуулаагүй, гүйцэтгэлийн баталгаа ирүүлээгүй гүйцэтгэгчийн байршуулсан 87.3 сая төгрөгийн тендерийн баталгааг улсын орлого болгоогүй зэрэг зөрчил илэрсэн.

Аудитаар нийт 11,384.2 сая төгрөгийн зөрчил илрүүлж гэрээ дүгнэж алданги тооцуулах, ажлын бодит гүйцэтгэлийг хянаж баталгаажуулах, хөрөнгө данс бүртгэлд бүртгэх тухай 166.9 сая төгрөгийн 3 албан шаардлага бичиж 11,431.4 сая төгрөгийн зөрчилд 23 зөвлөмж өглөө.

5.2. Мэргэжлийн боловсрол олгох үйл ажиллагааны үр дүн /Код: ДГА-2020/03-ГА, өөрийн санаачилгаар/

Аудитад аймгийн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төсвийн 2017-2019 оны хичээлийн жилийн үйл ажиллагааг хамруулан, 2020.05.18-ны өдрөөс 2020.06.30-ны өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэсэн.

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн **“Хөдөлмөрийн зах зээлийн суурь судалгаа байхгүйгээс мэргэжлийн боловсролыг иргэний сонирхол, хөдөлмөрлөх хэрэгцээнд тулгуурлан олгож байна”** гэсэн нэгдсэн дүгнэлтийг өгсөн.

МСҮТ-ийн суралцагчдаас зарим хичээлийн хэрэглэгдэхүүнийг авдаг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг зориулалт бусаар зарцуулсан, аймгийн хэмжээнд хөдөлмөрийн зах зээлийн судалгаа хийгдээгүй, тиймээс элсэлтийг хөдөлмөрлөх хэрэгцээ сонирхолд тулгуурлан зохион байгуулдаг, хөдөлмөрийн зах зээлд эрэлт, хэрэгцээтэй мэргэжлээр боловсрол олгож байгаа эсэх болон төгсөгчдийн ажил эрхлэлтэд аймгийн МХГ-аас хяналт шалгалт хийгээгүй зэрэг зөрчил илэрсэн.

Аудитаар нийт 8.8 сая төгрөгийн зөрчил илрүүлж, хөдөлмөрийн зах зээлийн судалгааг хийж, түүнд үндэслэн элсэлтийг зохион байгуулах 2 өгч, төсвийн төлөвлөлттэй холбоотой 8.8 сая төгрөгийн саналыг ҮАГ-т уламжилсан.

5.3. Орон нутгийн ИТХ-ын 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэл /Код: ДГА-2020/06-ГА, хуулийн дагуу/

Аудитад аймаг, сумдын сонгуулийн хороо, УБХ, ОБГ-ын сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлтэй холбоотой үйл ажиллагааг хамруулан, 2020.10.30-ны өдрөөс 2020.11.13-ны өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэлээ.

СЕХ-оос Дорноговь аймгийн сонгуулийн хороонд 16 нэр төрлийн зардалд нийт 358.5 сая төгрөгийн, УБЕГ-аас аймгийн УБХ-т 50.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Аймгийн сонгуулийн хороо нь сонгуулийн зардлын төсвийг СЕХ-оос ирүүлсэн зөвлөмж, аргачлалын дагуу сумдын сонгуулийн хороодод төсвийг хуваарилсан хэдий ч зарим зардлыг тооцож, олгохдоо зөвлөмж, аргачлалыг баримтлаагүй байна.

Аудитаар батлагдсан төсвийг зориулалт бусаар, арвилан хэмнэлтгүй зарцуулсан, холбогдох байгууллагын зөвшөөрөлгүй зардал хооронд шилжүүлэн зарцуулсан, аймгийн СХ-оос сумдын СХ-д тавих хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй зэрэг зөрчил илэрсэн.

5.4. Орон нутагт тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа дүрэм, журмын хэрэгжилт, үр дүн /Код: ДГА-2020/02-НА, өөрийн санаачилгаар/

Аудитад аймаг болон сумын Засаг даргаас 2017-2019 онд олгосон 5 төрлийн тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг хамруулан, 2020.05.01-ний өдрөөс 2020.06.30-ний өдрийг хүртэлх хугацаанд гүйцэтгэлээ.

Аудитаар **“Тусгай зөвшөөрөл бүхий байгууллагуудтай хамтарч ажиллах, тэдгээрийн хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг хангуулах шаардлагатай байна”** гэсэн нэгдсэн дүгнэлтийг өгсөн.

Аймгийн бодлогын баримт бичигт тусгагдсан тусгай зөвшөөрөл бүхий байгууллагуудтай холбогдох зорилтын хэрэгжилтүүд хангалтгүй, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн хязгаар тогтоосон эрх зүйн акт нь хүчин төгөлдөр бус байдлаас шалтгаалж аймгийн хэмжээнд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх аж ахуйн нэгжид олгосон тусгай зөвшөөрлийн тоо жилээс жилд нэмэгдсэн, тамхи худалдах цэгтэй ч 3 суманд тамхи худалдаалах тусгай зөвшөөрлийг олгоогүй, тусгай зөвшөөрөл олгосон байгууллагуудын талаар мэдээллийг ил тод мэдээлээгүй, эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход баримтлах тэргүүлэх чиглэлд тусгагдаагүй 9 тусгай зөвшөөрөл олгосон, тусгай зөвшөөрөл бүхий байгууллагууд тусгай зөвшөөрлийн хугацаанд стандарт дүрэм журмыг мөрдөж ажиллаагүй, хяналтаар өгсөн зөвлөмжийг тууштай хэрэгжүүлж ажиллаагүй байдлаас шалтгаалж мэргэжлийн байгууллагуудын хяналт шалгалтын үр дүн хангалтгүй зэрэг зөрчил дутагдал илэрсэн.

Аудитаар нийт 16.0 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 2.1 сая төгрөгийн зөрчлийг аудитын явцад барагдуулсан ба зөрчлийг арилгах 5.0 сая төгрөгийн 5 албан шаардлага бичиж бусад 8.9 сая төгрөгийн зөрчилд холбогдох албан тушаалтанд зөвлөмж хүргүүллээ.

5.5. МСҮТ болон ерөнхий боловсролын сургуулийн дотуур байр болон цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын зарцуулалт, үр дүн /код: ДГА-2020/03-НА, аймгийн ИТХ-ын захиалгаар/.

Аудитад тус аймагт үйл ажиллагаа явуулдаг нийт 52 боловсролын байгууллагаас түүвэрлэн 33 байгууллагын 2018-2019 оны хичээлийн жилийн хоолны зардлын зарцуулах үйл ажиллагааг хамруулан, 2020.05.07-ны өдрөөс 2020.06.30-ны өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэлээ.

Аудитын дүнд үндэслэн **“Хоолны зардлын нормативыг зах зээлийн үнэ ханштай уялдуулж батлаагүйгээс илчлэгийг бүрэн хангах боломжгүй байна”** гэсэн нэгдсэн дүгнэлтийг өгсөн.

Хүүхдийн хоногийн хоолны зардлын норматив хэмжээг зах зээлийн үнэ ханш, хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээнд үндэслэж батлаагүй, норматив хэмжээнд багтаан батлагдсан төсвийг бүрэн зарцуулахгүй,

нийт хоолны зардлын 20 хувь буюу 318.5 сая төгрөгийн хэмнэлтийг бусад зардалд шилжүүлэн зарцуулсан, үүнээс 27.3 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан, мэргэжлийн байгууллагуудаас хэрэгжүүлсэн хяналт шалгалтын үр дүн тодорхой бус, хүнсний материалын худалдан авах тоо хэмжээг технологийн карт, хүүхдийн тоо зэрэгт үндэслээгүй, технологийн карт боловсруулаагүй, зарим боловсруулсан картын дагуу хоолны цэсийг зохиодоггүй, хүүхэд өдөрт авбал зохих илчлэг нормыг бүрэн авч чадаагүй зэрэг зөрчил, дутагдал илэрсэн.

Аудитаар нийт 360.6 сая төгрөгийн зөрчил илрүүлж, холбогдох албан тушаалтнуудад 11 зөвлөмж хүргүүлээ.

5.6. Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилт /Код: ДГА-2019/18-НА, өөрийн санаачилгаар/

Тус аудитыг 2019 онд эхлүүлсэн бөгөөд 2020 оны 1 дүгээр сард аудитын тайланг дуусгасан.

Аудитын дүнд үндэслэн **“Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хуулиар хүлээсэн үүргийн биелэлт хангалтгүй байна”** гэж дүгнэлээ.

Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг 4-6 удаа сунгуулж хуулийн заалтыг зөрчсөн, хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн дийлэнх нь байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулаагүй, тухайн жилийн зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг байршуулаагүй, холбогдох мэргэжилтэн, байцаагч нар ажлын байранд тогтвор суурьшилтай ажиллаагүй, чиг үүргээ хангалтгүй биелүүлсэн, хариуцлага сул байдлаас шалтгаалж орон нутгийн төсөвт орох орлого бүрэн төвлөрөөгүй, компаниуд БОНБУ, БОМТ-ний хуулбар хувь, төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг аймаг, сумын Засаг даргад ирүүлээгүй, хамтын ажиллагааны хороог байгуулж ажиллаагүй, гэрээг дүгнэж үр дүнг тооцоогүй, МХГ-ын хяналт шалгалтаар илэрсэн зөрчил арилаагүй, давтагдан гарах зэрэг зөрчил илэрсэн.

Аудитаар нийт 1,958.4 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс аудитын явцад 50.0 сая төгрөгийн усны төлбөр төлүүлж, холбогдох албан тушаалтанд 8 зөвлөмж, нэг албан шаардлага хүргүүлээ.

5.7. Аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх орон нутгийн сонгуулийн тойрогт нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох /Код:ДГА-2020/04-НА, хуулийн дагуу/

Аудитаар нэр дэвшигчээс аймгийн ИТХ-ын сонгуулийн 22 тойрог, 14 сумын ИТХ-ын сонгуулийн нийт 65 тойрогт, нам, эвслээс аймгийн ИТХ-н болон 14 сумын ИТХ-н сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоолоо. Аудитыг 2020.06.15-2020.06.23-ны хугацаанд гүйцэтгэн, нам эвслээс санал авч, зардлын дээд хэмжээ тогтоосон тушаалыг 2020.06.26-нд баталгаажуулсан. Зардлын дээд хэмжээг 2020.06.30-нд олон нийтэд мэдээлсэн.

5.8. Орон нутгийн ИТХ-ын ээлжит сонгуулийн жилийн 06 дугаар сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд тухайн нам, иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивыг хянаж, баталгаажуулах /Код:ДГА-2020/05-НА, хуулийн дагуу/

Аймаг, сумын ИТХ-ын ээлжит сонгуульд оролцох намуудаас ирүүлсэн хандивын тайланг төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд, 2020.07.01-ний өдрөөс 2020.07.24-ний өдрийг хүртэлх хугацаанд хянан баталгаажууллаа. Дорноговь аймгийн Монгол Ардын намын хороо 15, Дорноговь аймгийн Ардчилсан намын хороо 15, “Шударга Иргэдийн Нэгдсэн Эвсэл” намын Дорноговь аймгийн Орон нутгийн зөвлөл 15, Хөдөлмөрийн үндэсний нам 15, Иргэний Хөдөлгөөний намд өгсөн хандивын тайланд 1 дүгнэлтийг тус тус гаргасан.

Хуулийн хугацаанд буюу 2020.09.23-ны өдөр хандивын тайланд өгсөн дүгнэлтийг www.dornogovi.audit.mn сайтад байршуулсан.

5.9. Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргах /Код:ДГА-2020/06-НА, хуулийн дагуу/

Тус аудитаар аймаг, сумдын ИТХ-ын сонгуульд оролцох нам болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт 2020.06.22-ны өдрөөс 2020.08.06-ны өдрийг хүртэлх хугацаанд гүйцэтгэж дүгнэлт гаргасан. Аймаг, сумын ИТХ-д оролцох нам, бие даан нэр дэвшигчдээс нийт 67 мөрийн хөтөлбөрийг дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн байна.

Мөрийн хөтөлбөрт санхүүжилтийн эх үүсвэр шаардагдах зорилт тусгасан хэдий ч дэлгэрэнгүй жагсаалтыг үйлдээгүй, арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэрийг тооцохдоо орон нутгийн төсвийн төсөөллийг баримтлаагүй, бодитой бус төлөвлөсөн, эх үүсвэр шаардах зорилтын холбогдох тооцоо судалгааг гаргаагүй зэрэг нийтлэг зөрчил илэрсэн.

Нам, бие даан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрт тусгагдсан зорилт арга хэмжээний 267 заалтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ, эх үүсвэрийг тусгуулах, АНСДИТХСТХ-ийн 37 дугаар зүйл 37.3-д нийцээгүй 25 заалтыг тус тус залруулсан.

Нам, бие даан нэр дэвшигчдэд хүргүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийг хянаж, Айраг, Эрдэнэ сумын ИТХ-д бие даан нэр дэвшсэн 11 нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийг хүчингүй болгосон.

Хуульд заасны дагуу 48 нам, 8 бие даан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрийг цахим сайтад байршуулж нийтэд мэдээлсэн.

6

ДОТООД АЖИЛ

6.1. Дотоод сургалт

Тус байгууллагын албан хаагчдын санал болон сургалтын эрэлт хэрэгцээ, мөн УАГ-ын сургалтын төлөвлөгөөтэй уялдуулан байгууллагын 2020 оны дотоод сургалтын төлөвлөгөөг боловсруулан, тэргүүлэх аудитораар батлуулсан.

Төлөвлөгөөнд байгууллагын албан хаагч зохион байгуулах 8, мэргэжлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх 2 сургалтыг тусгасан. Дотоод сургалтын төлөвлөгөөний дагуу дараах сургалтыг зохион байгуулаад байна. Үүнд:

- Санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэхэд баримтлах чиглэл сэдвээр 01 дүгээр сард,
- Нийцлийн аудитын журам, гарын авлага, хэрэглээ сэдвээр 06 дугаар сард,

- Залилангийн эрсдэлийг аудитад авч үзэх нь сэдвээр 07 дугаар сард,
- Ашиг, сонирхлоос урьдчилан сэргийлэх сэдвээр 07 дугаар сард,
- Аудитын эрсдэлийг тодорхойлох нь сэдвээр 08 дугаар сард,
- Ажлын баримт материал бүрдүүлэлт сэдвээр 10 дугаар сард тус тус зохион байгуулсан.



Дотоод сургалтын төлөвлөгөөнд албан хаагчдын зохион байгуулах 2 сургалтыг 12 дугаар сард зохион байгуулах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах сургалт цар тахал болон төсвийн хүрэлцээгүй байдлаас шалтгаалан зохион байгуулагдаагүй байна.

Байгууллагын дотоод сургалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй боловч албан хаагчид өөрсдийн мэдлэг чадварыг хөгжүүлэхэд анхаарч дараах сургалтад хамрагдсан байна. Үүнд:

- УАГ, Удирдлагын Академитай хамтран 2020 оны 05 дугаар сард зохион байгуулсан “Төрийн захиргааны ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц цахим сургалт”-д тус байгууллагын 3 ахлах аудитор хамрагдаж, амжилттай суралцсан.
- УАГ-аас 2020.05.29-нд зохион байгуулсан “Удирдах ажилтны семинар”-т ахлах аудитор Ч.Ариунаа оролцсон.
- ММНБИ-ээс 2020 оны 05 дугаар сард зохион байгуулсан “Аудиторын эрх олгох онлайн сургалт”-д тус байгууллагын 4 албан хаагч хамрагдаж, 3 албан хаагч амжилттай суралцсан.
- Удирдлагын Академийн мэргэшүүлэх дипломын сургалтад ахлах аудитор Ч.Ариунаа суралцаж төгссөн.
- Удирдлагын Академийн Төрийн удирдлагын магистрын ангид аудитор Ч.Хэрлэнчимэг суралцаж байна.
- УАГ-ын сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу 2020 оны 07-11 дүгээр саруудад цахим хэлбэрээр зохион байгуулагдсан “Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулга” сэдэвт сургалтад 9 албан хаагчид хамрагдаж, шалгалтыг амжилттай өгсөн.

6.2. Архив, бичиг хэрэг

Байгууллагын баримт бичиг нягтлан шалгах комиссыг 4 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, 2020 онд хэрэгжүүлэх 23 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг боловсруулан, батлуулсан. Төлөвлөгөөний дагуу устгах баримтын жагсаалтыг гарган ажилласан.

Тайлант хугацаанд нийт 839 албан бичгийг бусад байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, 791 албан бичгийг хүлээн авч, шийдвэрлэсэн байна. Тайлант онд байгууллагын архивт албан хаагчдаас байнга хадгалагдах 9 боть, түр хадгалах 84 боть материалыг хүлээн авч бүртгэсэн.

6.3. Ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа

Монгол даатгал ХК-тай гэрээ байгуулан 11 албан хаагчийг хөдөлмөрийн чадвар түр алдсаны болон гэнэтийн ослын даатгалд хамруулан нийт 704.0 мянган төгрөгийг зарцуулсан.

6.4. Дотоод зохион байгуулалтын бусад асуудал

- Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, нийт 5 арга хэмжээг төлөвлөн, хэрэгжүүлсэн.
- Төрийн болон албаны нууцын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор 7 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжүүлэн ажилласан.
- УАГ-ын audit.mn цахим хуудаст төрөлжсөн аудитын 150 тайлан, өдөр тутмын үйл ажиллагаа, байгууллагын мэдээллийн самбарт санхүүгийн аудит, гүйцэтгэл, нийцлийн аудитын албадын тайлант онд хийсэн аудитын талаарх товч мэдээллүүдийг тогтмол шинэчлэн ажиллаж байна.
- УАГ-ын Чанарын баталгаажуулалтын албанаас хийсэн шалгалтаар өгсөн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх 17 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг боловсруулан, аудитын үе шат бүрд хэрэгжүүлэн ажиллаж байна.

6.5. Хүний нөөц, шагнал урамшуулал

- Тус байгууллагын аудитор П.Энхбаяр нь 2020 оны 03 дугаар сард төрийн дээд “Алтан гадас” одонгоор шагнагдсан.



- Байгууллагын аудиторовын сул орон тоог нөхөж, МУЕА-ын аудиторовын тушаалын дагуу Л.Равдандоржийг 2020.02.01-ний өдрөөс аудитораар ажиллуулж байна.
- Тайлант оны 03 дугаар сард хүүхэд асрах чөлөөтэй байсан аудитын менежер Ч.Хэрлэнчимэг ажил, албан тушаалдаа эргэн орсон.
- Ахлах аудитор О.Нарангарав 2020 оны 05 дугаар сараас жирэмсэн, амаржсаны чөлөө авсан.
- Албан хаагч Ч.Ариунаа, Ч.Хэрлэнчимэг нарын албан тушаал өөрчлөгдөж, ахлах аудитор, аудитораар ажиллаж байна.
- Байгууллагын дарга, тэргүүлэх аудитораар 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрөөс Т.Ган-Өлзий томилогдон ажиллаж байна.
- Ахлах аудитор Ц.Лүндэгмаа нь 2020 оны 12 дугаар сарын 14-ны өдрөөс өндөр настны тэтгэвэрт гарсан.
- Аудитор П.Энхбаяр шилжин ажилласан, ахлах аудитор О.Нарангарав хүүхэд асрах чөлөөтэй байгаатай холбоотойгоор 2 гэрээт аудиторовыг ажиллуулж байна.

6.6. Шинэ санал, санаачилга.

Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар 2020 онд дараах ажлуудыг шинээр санаачлан хэрэгжүүллээ. Үүнд:

- Аудитаар өгөгдсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулах зорилгоор аймгийн Прокурорын газартай хамтран ажиллах санамж бичиг байгуулан, зарим төлбөрийн акт, албан шаардлагыг хэрэгжилтийг хангуулахаар шүүхэд нэхэмжлэгчээр оролцуулах хүсэлтийг гаргаад байна.
- Тус байгууллагын аудитын үйл ажиллагаатай холбоотой гарч буй зарим асуудлыг дотооддоо шийдвэрлэх зорилгоор аудитор бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгайлсан сэдвийг тусгуулсан. Үүний хүрээнд аудитор бүр шийдвэрлэх асуудлыг судалж, дүн шинжилгээ хийн, дүгнэлт боловсруулж цаашдын үйл ажиллагаанд мөрдөн ажиллах болно. Тухайлбал, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байгаад шинжилгээ хийх, албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд шинжилгээ хийх гм.
- Нийцлийн болон гүйцэтгэлийн аудитын үе шат бүрд материаллаг байдлыг тодорхойлж, авч үзэх ажлыг тодорхой болгох үүднээс байгууллагын хэмжээнд мөрдөх загвар маягыг боловсруулж, аудитад ашиглаж байна.

7 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан мэдээ. Байгууллагын нягтлан бодох бүртгэлийг УСНББОУС, нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох журмын дагуу хөтөлж, 2019 оноос НББ-ийн үйл ажиллагаанд “Unicus” программыг ашиглаж байна.

Тайлант онд 512.4 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 477.3 сая төгрөгийн санхүүжилттэй, 433.8 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Нэмэлт санхүүжилтийн дансанд аудитын үйлчилгээний төлбөрт нийт 102.3 сая төгрөг төвлөрч, ХАК-уудад 67.2 сая төгрөг шилжүүлээд байна.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээ, татвар, НДШ-ийн тайланг хуулийн хугацаанд нь гаргаж холбогдох байгууллагад хүргүүлсэн. Мэдээллийн ил тод байдлыг хангах ажлын хүрээнд шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь тогтмол байршуулан, илгээж байна.

Хөрөнгө, өмч. Тэргүүлэх аудиторов 2020 оны А/18 тоот “Эд хөрөнгийн тооллого явуулах тухай” тушаалын дагуу байгууллагын хөрөнгийн хагас жилийн тооллогыг зохион байгууллаа. Тооллогоор дутагдал илрээгүй ба цаашид ашиглах боломжгүй, эвдэрч гэмтсэн 13 нэр төрлийн 23 ширхэг, 1,976.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 15 нэр төрлийн 56 ширхэг 958.9 мянган төгрөгийн бараа материалыг актлах саналыг өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, холбогдох материалыг бүрдүүлэн, удирдлагад танилцуулж, ҮАГ-т албан тоотоор хүргүүллээ.

Тайлант оны жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг зохион байгуулах тухай дарга, тэргүүлэх аудиторов тушаал гарч, тооллогыг 12 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэх төлөвлөгөөтэй байна.

8

ТӨЛБӨРИЙН АКТ, АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛАХ АЖИЛ

Тайлант онд тогтоосон болон өмнөх онуудаас шилжин ирсэн, хэрэгжээгүй төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр дараах ажил хийгдсэн. Үүнд:

- Статистик мэдээний бүртгэлийг аудитуудаар сар бүр гаргуулж, байгууллагын нэгтгэсэн мэдээг гаргасан.
- Хугацаа дууссан төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн үлдэгдэлд дүн шинжилгээ хийж, аудитуудад цаашид авах арга хэмжээний талаар чиглэл өгч, хэрэгжилтийг хянав.
- Шалгагдагч байгууллагын эрх бүхий албан тушаалтан өөрчлөгдсөнтэй холбоотойгоор өмнөх онуудад өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт бүрэн хангагдахгүй байсан. Иймд дахин албан бичиг явуулах, шалгагдагч байгууллагатай хамтран ажлыг зохион байгуулсан.

9

ДҮГНЭЛТ, САНАЛ

9.1. Дүгнэлт

Төрийн аудитын байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хүрээнд 2020 онд нийт 64 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үүнээс бүрэн хийж гүйцэтгэсэн 48 арга хэмжээ, дутуу хийгдсэн 7 арга хэмжээ, тодорхой шалтгааны улмаас хийгдээгүй 9 арга хэмжээ байна.

Тайлант оны 12 дугаар сарын 15-ны байдлаар санхүүгийн тайлангийн 212 аудит, гүйцэтгэлийн 6, нийцлийн 8 аудитыг гүйцэтгэсэн. Тайлант онд хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй 2 нийцлийн аудитыг тайлант оны 12 дугаар сарын 25-30-нд дуусгах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

ТАГ-ын 2020 онд гүйцэтгэсэн аудитаар нийт 236,565.4 сая төгрөгийн 1128 алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 202,539.5 сая төгрөгийн 528 алдааг залруулж, 74.2 сая төгрөгийн зөрчилд 60 төлбөрийн акт, 2,861.8 сая төгрөгийн зөрчилд 112 албан шаардлага тогтоож, 31,089.9 сая төгрөгийн зөрчилд 410 зөвлөмж, 18 албан тушаалтанд хариуцлага тооцох 11 албан шаардлага хүргүүлээ.

Тайлант онд тогтоосон акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг авч үзэхэд 70.7 сая төгрөгийн 50 төлбөрийн акт барагдаж, биелэлт 95.2 хувьтай, 2,091.4 сая төгрөгийн 78 албан шаардлага хэрэгжиж /хугацаа болоогүй 508.2 сая төгрөгийн 14 албан шаардлага/, биелэлт 74.3 хувьтай, 20,891.3 сая төгрөгийн 301 зөвлөмж хэрэгжиж /хугацаа болоогүй 2,718.9 сая төгрөгийн 20 зөвлөмж/, биелэлт 76.3 хувийн хэрэгжилттэй байна.

9.2. Санал

Байгууллагын үйл ажиллагаанд үүсч буй хүндрэл бэрхшээл, цаашид хөгжүүлэх шаардлагатай асуудлыг шийдвэрлэх зорилгоор дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

Аудитын үйл ажиллагаа, арга хандлагатай холбоотой:

- Улс орон нутгийн төсвөөр хийгдсэн хөрөнгө оруулалт, орон нутгийн хэтийн болон жилийн зорилтын хэрэгжилт зэрэг аудитыг зэрэгцээ хэлбэрээр хийж, тухай бүр дүгнэлт, зөвлөмж өгч ажилласнаар алдаа, зөрчлийг гарах эрсдэлийг бууруулж, нийгэмд үзүүлэх үр нөлөөг нэмэгдүүлэх боломжтой юм.
- ТАБ-аас гүйцэтгэсэн аудитын мэдээллийг /илэрсэн алдаа зөрчил, шийдвэрлэлт, барагдуулалт, үр өгөөж зэрэг/ бүртгэх программ хангамжийн тусламжтайгаар бүртгэснээр байгууллагын статистик үзүүлэлтийг өдөр тутам авах, ТАБ-ын хэмжээний мэдээллийг тухай бүр нэгтгэн харах боломжтой болно. Мөн статистик мэдээ тайлан бэлтгэхэд үүсдэг хүндрэл бэрхшээл буурна.

Төрийн аудитын байгууллагын хэмжээнд ойрын болон хэтийн бодлого, төлөвлөгөөнд тусгах санал, санаачилга:

- Албан хаагчдыг гадаадын сургалтад үе шаттайгаар хамруулж, албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлснээр аудитыг илүү үр өгөөжтэй, үр нөлөөтэй гүйцэтгэх боломжийг нэмэгдүүлнэ.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Т.ГАН-ӨЛЗИЙ



Хаяг: Дорноговь аймаг, Сайншанд сум
Орон нутгийн өмчийн III байр
Утас, факс: 70522734
Вэб: www.dornogovi.audit.mn